

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04-р сарын 26-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн №01 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.СОЁЛ-ЭРДЭНЭ

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04-р сарын 26-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ ЧӨЛӨӨЛЖ, ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлэг болон “Сүү” ХК-ийн 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн № 01 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгосугай.

2. “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ердийн гишүүнээр:

1. Д.Ганбаатар
2. Д.Цэрэнжигмэд
3. Б.Түвшинтөгс
4. Д.Жамъян
5. Д.Уянгалянхуа
6. Ц.Соёл-Эрдэнэ
7. Д.Тунгалаг
8. С.Сүхболд

Хараат бус гишүүнээр:

1. Н.Цэрэндорж
2. Ш.Даваалимбэ
3. Г.Баяр
4. П.Мэндсайхан

ХУРЛЫН ДАРГА



Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04-р сарын 26-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 5 дугаар бүлэг болон “Сүү” ХК-ийн 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн № 01 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт: “...Англиар: “Milk” Joint stock Company...” гэж заасан хэсгийг “...Англиар: “Suu” Joint stock Company...” гэж өөрчлөн найруулсугай.

2. “Сүү” ХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэгт: “Үндсэн ба эргэлтийн хөрөнгийг дахин үнэлж, үнэлгээний зөрүүг бүртгэлд тусгасан тохиолдолд өөрийн хөрөнгө ба хувьцааны балансын үнэ нэмэгдэж, хорогдоно” гэж заасан хэсгийг “Үндсэн ба эргэлтийн хөрөнгийг дахин үнэлж, үнэлгээний зөрүүг бүртгэлд тусгасан тохиолдолд өөрийн хөрөнгө нэмэгдэж, хорогдоно” гэж өөрчлөн найруулсугай.

3. “Сүү” ХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт: “Хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 50 болон түүнээс дээш хувь нь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно” гэж заасан хэсгийг “Хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно” гэж өөрчлөн найруулсугай.

4. “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.20 дахь хэсэгт: “ТУЗ-ийн гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Гишүүн нь эсрэг саналтай байвал түүнийгээ протоколд тэмдэглүүлэх эрхтэй” гэж заасныг компанийн дүрмээс хассугай.

5. “Сүү” ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг Хавсралт ёсоор баталсугай.

6. “Сүү” ХК-ийн шинэчилсэн дүрэм холбогдох тогтоол, шийдвэрийг эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг “Сүү” ХК-ийн Гүйцэтгэх захирал /М.Мандхай/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ